



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 23 өдөр

Дугаар А/710

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2016 оны 234 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 4/03 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улаан загалмайн хорооны нөөц сан бүрдүүлэх, Улаанбаатар хот болон бүсийн төвөөс тусламжийн бараа татах, сумдад сургалт сурталчилгаа явуулах арга хэмжээний зардалд зориулж 20 000 000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Зардалд зарцуулагдах 20 000 000 төгрөг /Хорин сая/-ийг Хөшөөт хөгжил сангийн хөрөнгөөр 2021 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр арга хэмжээний 5.1 дэх "Үйл ажиллагааны хөтөлбөр /Улаан загалмайн хороо/-өөс тооцож гаргахыг Хөшөөт хөгжил сангийн захирал /Т.Мягмардорж/, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Дэлгэрсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2021 оны
11 дүгээр сарын 23-ны өдрийн
А/710 дугаар захирамжийн хавсралт



УЛААН ЗАГАЛМАЙ ХОРООНЫ НӨӨЦИЙН САН БҮРДҮҮЛЭХ
ТӨСВИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

Мянган төгрөг

№	Үйл ажиллагаа	Зардлын төсөв	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Гамшгийн бэлэн байдлыг хангах зорилгоор аймгийн Улаан загалмайн хороонд гамшгийн нөөц бүрдүүлэх	Хүнсний багц /гурил, будаа, сахар, тос/	Багц	150	70,0	10,500,0
		Ариун цэврийн багц	Багц	50	50,0	2,500,0
		Хөнжил гудас /хос/	Хос	40	90,0	3600,0
2	Ачаа бараа тээврийн зардал	Бэлэн хувцас	Боодол	40	20,0	800,0
		Малын эрдэс тэжээл	Тонн	2	250,0	500,0
		Ариутгалын материал	Тонн	0,5	300,0	150,0
3	Сумдад тусламжийн бараа материалыг хүргүүлэх болон нийгмийн халдварт өвчин ковид-19 эсрэг сургалт, сурталчилгаа хийх, анхан шатны хороог бэхжүүлэх	Сумдад явсан шатахууны зардал	Литр	250	2,2	550,0
		Сурталчилгааны материал	Ширхэг	1000	0,8	800,0
		Сумдад ажилласан томилолт	Хоног	30	20,0	600,0
Зардлын дүн						20000,0

-oOo-